

Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны “Галын ерөөлийн судар хэмээгдэх оршив”
зохиолын тухайд өгүүлэх нь

Оюун*

Бүгд найрамдах Хятад ард улс,
Бортохой дээд сургууль

Received: Aug 08, 2025 | Revised: Oct 31, 2025 | Accepted: Dec 15, 2025

Хураангуй: Тус өгүүлэлд Урадын Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны 1783 онд модон бараар хэвлэгдсэн "Очир дара мэргэн даяанч ламын гэгээний бум зарлиг хэмээгдэх оршивой" гэх дөрвөн боть сүмбүмд байгаа "Галын ерөөлийн судар хэмээгдэх оршивой" зохиолоор үндсэн эх болгон, бичмэл дармал хэвлэлүүдийг харьцуулан улирч хувирсан онцлог, Мэргэн гэгээний галын судрын агуулга, утга санаа, туурвил зүйн онцлогийг задлан шинжилсэн болно.

Түлхүүр үг: Мэргэн гэгээн, Лувсандамбийжалцан, Галын судар, онцлог

A Discussion on the Text Known as "The Sutra of Fire Blessing"
by Mergen Gegeen Luvsandambijantsan

Wuyun

Bortokhoi University,
Inner Mongolia, China

Abstract: This article takes as its primary source the work entitled "The Sutra of Fire Blessing," which is found within the four-volume woodblock-printed collection from 1783 known as "The Decree of Vajradhara Mergen Da Yanchi Lama's Enlightenment," by Urad's Mergen Gegeen Luvsandambijaltsan. The study conducts a comparative analysis of manuscript and print versions to trace the characteristics of their transmission and variation. Furthermore, it provides a detailed analysis of the content, ideological meaning, and stylistic features of Mergen Gegeen's "Sutra of Fire."

Key words: Mergen Gegeen, Luvsandambijaltsan, The Sutra of Fire, characteristics

1. Удиртгал

Урадын Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан бол XVIII зууны үеийн их бичгийн хүн, буддын гүн ухаантан, бурхан шашны нэрт зүтгэлтэн, утга зохиолын гол

* © Оюун 2025
Email: baowuyun50@gmail.com

төлөөлөгчийн нэг мөн. Түүний шавь олондоо сургасан сургаалын зохиол, шүлэг дуу, түүхийн зохиол, бурхан шашны зан үйлийн зохиол, сан тахилга, ерөөл, магтаал зэрэг олон төрлөөр бичсэн зохиолууд нь бидний үед уламжлан иржээ. Мөн бурхан шашны ном судрын монгол уншлагыг дэлгэрүүлж, энэтхэг төвөд хэлнээс бурхан шашны холбогдол бүхий зохиолуудыг орчуулж, шашны зан үйлийн болон эм эмнэлгийн судруудыг шинээр бичиж, монгол хэлний сурах бичиг зохиох зэрэг шашин, соёл, түүх, утга зохиол, хэл, зан үйлийн холбогдолтой бүтээл туурвисны дотроос “Галын ерөөлийн судар хэмээгдэх оршив” зохиолын тухай энд өгүүлэе.

Мэргэн гэгээний галын судрыг анхаарч шинжилсэн судлаачдаас дурдвал: Германы монголч эрдэмтэн В.Хайссиг "Монголын шашин суртахуун" гэх номдоо "арван наймдугаар зууны дунджаар амьдарч байсан Урадын мэргэн гэгээн Лувсандамбийжалцан бол ламын шашин болон бөөгийн шашныг уялдуулах талаар онцгой үйлдэл үзүүлжээ. Тэр бээр бөөгийн шашны үзэлт ба эзэд сахиусыг ламын шашны ёс горимтой уялдуулсан уншлага дуудлагын судар олныг бичжээ. Тэр бээр бас овоо тахих, гал тахих ба гэр мялаах ерөөл магтаал олныг бичиж, монголчуудын урьдын ерөөл, магтаалын дотор ламын шашны агуулгыг оруулж бөөгийн шашны эзэд сахиусыг бурхан шашны ёс горимд оруулж тавьсан байна.” гэжээ (Хайссиг, 2013: 84).

Эрдэмтэн Ч.Хишигтогтох “Монголчуудын гал тахилгын түүхээс - цахар гэвш Лувсанцүлтэмийн Галын судрын жишээн дээр” өгүүлэлдээ: “Эзнээ хошууны гал тахилгын ерөөлд: Эвт журмаас болсон /Энэтхэг улсын тахисан..... тавт мэргэдээс болсон/ Төвөд улс бас тахисан..... гэрэлтэх ёсноос болсон/ Хятад улс бас тахисан Үнэн Монгол Улс тахисан/ Өндөр төгс цогт галын хаан гэж шүлэглэсэн байдаг нь эртний Персийн гал тахилгын шашны урьдаар Энэтхэгт ороод тэндээс Төвөд, Хятад, Монголд дэлгэрсэн түүхийг тусгаж байгаа юм” (Хишигтогтох, 2013: 189) гэгчээр гал тахилгын дэлгэрэлтийн түүхийн тухай өгүүлжээ. Энд Эзнээ хошууны гал тахих ерөөл гэж хэлж байгаа боловч энэ нь үнэндээ Мэргэн гэгээний галын ерөөлийн бадгууд юм.

Эрдэмтэн Ү.Наранбат "Мэргэн гэгээний зохиосон ерөөл даллагын шүлгүүдэд жишээлбэл “галын ерөөл” түгээмэл дэлгэрсэн бөгөөд лам нараар зогсохгүй, харчуулын дотроо түүнийг цээжилсэн хүн олон, жил бүрийн галын хорин гурванд хөдөө айлууд лам залж эс амжвал хар хүн ч түүнийг уншиж галаа тахидаг заншилтай байдаг.” гэжээ. (Галлуу, 1986: 23).

Эрдэмтэн Н.Сайшаалт “Мэргэн гэгээний шүлгийн шад тэгшлэлт хийгээд монгол хэмжээт шүлгийн төлөвширлийн тухай” (Батцагаан, 2007: 376) гэх өгүүлэлд Мэргэн гэгээний шүлгийн шад тэгшлэх онцлог нь монгол хэмжээт шүлгийн төлөвшрөлд үзүүлсэн нөлөөний тухай өгүүлэхдээ “галын ерөөл”-ийн мөр бадгаар жишээлэн задалсан байдаг. Ба.Мөнх “Шад тэгшлэх” гэдгийг мөрүүдийн айзам цохилгын тоог тэнцүүлэх гэж томьёолсон бөгөөд “айзам цохилгыг тэнцүүлэх” гэдгийг “шүлгийн үг ба үеийн тооны тэнцүүрхэл, үг буюу үеийг уншихад хэрэгсэх цагийн хэмжээнд захирагдсан байгалийн таслалт” (Мөнх, 2004: 394) хэмээн томьёолоод, энэ хэсгийг “айзам цохилго” хэмээн нэрлээд, Мэргэн гэгээний яруу найргийн дотор дөрөв, тав, зургаа, долоо, найман айзам цохилгод баримтлагдсан шүлэг ихэнх тоог эзэлдэг гэж хураангуйлж, Мэргэн гэгээний галын судрыг таван айзам цохилгоор шад тэгшилсэн гэжээ.

Эрдэмтэн Ба.Мөнх бас 2019 онд “Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан хийгээд түүний зохиол бүтээлийн тухай” гэх өгүүлэлдээ “Галын ерөөлийн судар хэмээгдэх оршив”-ын агуулгын тухай алхам дараалан танилцуулсан байна.

Дээрх эрдэмтэд Мэргэн гэгээний галын ерөөлийн тухай тал бүрээс нь өгүүлсэн боловч Мэргэн гэгээний галын ерөөлийг нэг бүтэн цогцоор шинжилж судалсан нь арай дутмаг байна. Мэргэн гэгээний галын ерөөлийг бүтэн цогцоор гүнзгий задалж шинжлэх нь ламын шашны нөлөө, ламын шашин ба бөөгийн шашинд галын сахиусны дүр төрхийн хувиралтын байдал, галын үүслийн тухай үзэлт танилтын хувиралт, гал тахих ерөөлийн уугал загварын улирал хувирлын жам, жич Мэргэн гэгээний зохиол туурвилын онцлогийг ойлгоход ач холбогдолтой.

2. Судалгааны арга, эх хэрэглэгдэхүүн

Энэхүү өгүүлэлд Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд хадгалагдаж буй *yal-un irügel orusiba*, *yal tngri-yin takily-a*, *yal-un takilq-a orusiba*, *yal-un takilay-a orusiba*, *ejen boyda-yin sang*, “Мэргэн даяанч ламын гэгээний бум зарлиг хэмээгдэх оршвой” зэрэг гар бичмэл болоод барын ном судрыг голлох эх хэрэглэгдэхүүнээр тус тус ашигласан болно. Уг өгүүлэлд холбогдох сурвалж бичгүүдийг хам болон цуваа цагийн үүднээс судалж, ашигласан сурвалжуудад эх бичгийн харьцуулсан судалгаа хийж, дурдагдаж буй эх бичгүүдийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг аргыг хэрэглэв.

3. Судалгааны хэсэг

Нэг. Мэргэн гэгээний галын судрын бар хэвлэл.

Мэргэн гэгээний галын судар нь зохиогдсоноос өдгөө хүртэл нийт ард олны дунд бичмэл болон дармал хэлбэрээр түгээмэл тархжээ. Мэргэн гэгээний “Очирдара Мэргэн даяанч ламын гэгээний бум зарлиг хэмээгдэх оршвой” гэх дөрвөн боть сүмбүм нь 1783 онд Бээжинд модон бараар хэвлэгдсэн бөгөөд үүний бяцхан “а” буюу дөрөвдүгээр ботийн 21 дүгээр ном нь бидний энд хэлэлцэн буй “Галын ерөөлийн судар хэмээгдэх оршив” болно.

Галын судар нь модон бараар тархсанаас гадна гар бичмэлээр ч тархсан байдаг. Одоогоор бидэнд олдоод буй таван гар бичмэлийг танилцуулбал доорх мэт.

1. *yal-un irügel orusiba* (Галын ерөөл оршив) нэрт бичмэл эх. Цаас. Чин улс (1616-1912) -ын дундаж үеийн хулсан үзгийн бичмэл. Хэмжээ нь 7.6×18.9 см. БНХАУ-ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд 49.72/343/:1 дансны дугаартай буй. Нийт 10 хуудас, төгсгөлийн хуудсанд Мэргэн гэгээний “Гэрийн ерөөл” -өөс хоёр бадгийг дагалдуулжээ.

2. *yal tngri-yin takily-a* (Гал тэнгэрийн тахилга) нэрт бичмэл эх. Цаас. Чин улс (1616-1912) -ын дундаж үеийн хулсан үзгийн бичмэл. Хэмжээ нь 7.3×22.2 см. БНХАУ-ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд 49.72/189/:1 дансны дугаартай хадгалагдаж байна. Нийт 10 хуудас.

3. *yal-un takily-a orusiba* (Галын тахилга оршив) нэрт бичмэл эх. Цаас. Чин улс (1616-1912) -ын дундаж үеийн хулсан үзгийн бичмэл. Хэмжээ нь 5.9×14.4 см. БНХАУ-

ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд 49.72/342/:1 дансны дугаартай байна. Нийт 12 хуудас.

4. *γal-un takilay-a orusiba* (Галын тахилга оршив) нэрт бичмэл эх. Цаас. Чин улс (1616-1912)-ын дундаж үеийн хулсан үзгийн бичмэл. Хэмжээ нь 7×30.5 см. БНХАУ-ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд 49.72/206:3 дансны дугаартай хадгалагдаж байгаа болно. Нийт 8 хуудас. Тус гар бичмэлд хоёр зүйлийн галын судар багтсан байна. Эхний гурван нүүр нь “Тулганы тэнгэрийг тахихуй ёсон”, үлдсэн 5 хуудсанд “Галын тахилга оршив” хэмээн гарчиглаад Мэргэн гэгээний галын судрыг бүрэн сийрүүлсэн байна.

5. *ejen boyda-yin sang* (Эзэн богдын сан) нэрт бичмэл эх. Цаас. Чин улс (1616-1912)-ын сүүлч үеийн үсэн үзгийн бичмэл. Хэмжээ нь 21.8×10.8 см. БНХАУ-ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд 49.720/9/:3 дансны дугаартай хадгалагдаж байна. Нийт 31 хуудас. Тус гар бичмэлд “Эзэн богдын сан”, “Галын ерөөл”, “Ариун сан” гэх гурван судар бий. Эл гар бичмэлийн 12-24 нүүрийн хооронд Мэргэн гэгээний галын судрыг бүрэн сийрүүлжээ.

Энэ таван гар бичмэлийг тулгаж үзэхэд өмнөх дөрвөн бичмэл нь үг үсгийн хувьд зөрөх газаргүй мөртөө Мэргэн гэгээний сүнбүмийн дөрөвдүгээр ботид байгаа “Галын ерөөлийн судар хэмээгдэх оршив”-той ижил байна. Харин нэлээд сүүл үед хуулагдсан “Эзэн богдын сан” гэх бичмэл дэх “Галын ерөөл” нь нэмэгдэж хасагдсан зүйл буй. Тухайлбал өмнөх арван бадгийн төгсгөл болгонд “Ийн жаргал заяан атугай” гэх өгүүлбэр, 18-25 дугаар бадгийн ард “хурай хурай” гэх үг нэмэгдэж, 16 дугаар бадгийн “уувай, уувай” гэх үг нь хасагджээ. Энэ байдал нь Чин улсын сүүлчийн үеэс Мэргэн гэгээний “Галын ерөөл”-ийг хуулан тархаах үед нэгэнт хувиралт гарсан гэдгийг гэрчилж байна.

1959 онд академич Ц.Дамдинсүрэн “Монгол уран зохиолын дээж зуун билэг оршвой” хэмээх цоморлигт “Галын ерөөлийн судар оршив” хэмээх нэрээр Мэргэн гэгээний галын ерөөлийг оруулахад “Ач үрийн хишиг соёрх”, “Эрх хүчний хишиг соёрх”, “Хүн ёс журам өлзийтэй” гэх гурван өгүүлбэр нь гээгджээ.

Урад нутгийн эрдэмтэн С.Галлуу, Г.Жарантай нар 1986 онд “Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны бум зарлиг хэмээгдэх оршив” гэх Мэргэн гэгээний зохиол бүтээлийн аман сурвалжийг хэвлүүлэхдээ “Галын ерөөл оршвой” нэрээр Мэргэн гэгээний галын судрын өмнө нь “Галын сан”, ард нь “Даллага авах”, “Өлзий оршил” гэх хэсгүүдийг нэмж дөрвөн хэсэг болгожээ.

1998 онд “Мэргэн гэгээн судлал”-ын найруулах зөвлөлийн хэвлүүлсэн “Очирдара Мэргэн даяанч ламын гэгээний бум зарлиг хэмээгдэх оршив” ба 2012 онд Мэргэн сүмийн цорж багш С.Мөнхбат “Мэргэн хийдийн судрын чуулган” зэрэгт Мэргэн гэгээний модон бараар хэвлэгдсэн зохиол бүтээлүүдийг гэрэл зургийн хэлбэрээр хэвлүүлсэн тул Мэргэн гэгээний галын судрыг уул төрхөөр нь үзэх боломжтой болсон нь сайшаалтай юм.

Бид Мэргэн гэгээний 1783 онд Бээжинд модон бараар хэвлүүлсэн “Очирдара Мэргэн даяанч ламын гэгээний бум зарлиг хэмээгдэх оршвой” гэх дөрвөн боть сүнбүмийн дөрөвдүгээр ботийн 21 дүгээр зохиол болох “Галын ерөөлийн судар

хэмээгдэх оршив" зохиолыг эх хэрэглэгдэхүүн болгож Мэргэн гэгээний галын судрын онцлогийг задлан шинжилье.

Хоёр. Мэргэн гэгээний галын судрын агуулга, утга санаа.

Мэргэн гэгээний “Галын ерөөлийн судар хэмээгдэх оршив” нь нийт 30 бадагтай, тахилын шүлэг, галын үүсэл, галын бурханд тахил өргөх, галын бурхнаас хишиг гуйх, галын бурхнаас даллага авах, өлзий өгүүлэх гэх зургаан агуулгаас бүрдэж байна.

“Галын ерөөлийн судар хэмээгдэх оршив”-ын эхний бадаг нь тахилын шүлэг болох юм. Тухайлбал:

“Рам ширий зуул рам

Рамын үсгээс болсон

Рашаант хумх барьсан

Раднаа эрихийг татсан

Ранза галаа ханд мөргөмүү” гэх мэтээр галын хаандаа сүсэглэн мөргөсөн тахилын шүлгээр эхлүүлсэн байна.

“Галын ерөөлийн судар хэмээгдэх оршив”-ын 2-10 дугаар бадагт галын үүсэл, гал тахилгын дэлгэрэлт, галын онцлог шинжийн тухай шүлэглэжээ.

Жишээ нь: Галын судрын хоёрдугаар бадагт:

“... Эсрүүн тэнгэрээс болсон

Эртний Богд ард тахисан

Элдэв төгс цогт галаа хан

Эрдэнэт ари тэнгэр ...” (Лувсандамбийжалцан, 1783: 2204)

Үүний нэгдүгээр мөрд нь галыг “Эсрүүн тэнгэрээс болсон” гэж, 3-10 дугаар бадгуудын эхний мөрд “Хурмастаас болсон”, “Вишнү тэнгэрээс болсон”, “Махишвариас болсон”, “Эвт журмаас болсон”, “Төвт мэргэнээс болсон”, “Ёсноос болсон”, “Өршөөлөөс болсон”, “Гурван эрдэнээс болсон зээллэг” (Лувсандамбийжалцан, 1783: 2205) гэх мэтээр галыг “Хурмаст, Вишнү, Махешвари тэнгэр” ба “журам, мэргэн, ёсон, өршөөл, гурван эрдэнээс болсон” гэжээ. Эсрүүн, Хурмаст, Вишнү, Махешвари нь бурхны шашны тэнгэрүүд, гурван эрдэнэ гэдэг нь ч бурхан номын чухаг гурван дээд, “журам, мэргэн, ёсон, өршөөл” гэдэг нь бурхны шашны сахил санваарууд болох юм. Үүний тухай Мэргэн гэгээн бээр 1763 онд зохиосон “Алтан товч” зохиолын 33 дугаар бүлэгт “Таван чанар хэмээвээс өршөөл, журам, ёс, мэргэн, бат. Ихэтгэж тавибаас хамаг л ертөнцийн тогтоолго бий, багатгаж татваас нэгэн биеийн ахуй чанар бий. Төрийн зүгт аваас бичиг цэрэг хоёулын сурлага ч болмуй, номын зүгт аваас судар тарнийн сурлага ч болмуй. Амин нядлахыг цээрлэх өршөөл, эс өгсөн үл авах журам, буруугаар үл хурьцах ёс, согтохыг цээрлэх, мэргэн худал үл өгүүлэх бат” (Лувсандамбийжалцан, 1763: 221) гэгчээр өршөөл гэдэг нь амь нядлахыг цээрлэх, журам гэдэг нь эс өгснийг үл авах, ёс гэдэг нь буруугаар үл хурьцах, мэргэн гэдэг нь согтохыг цээрлэх мэргэн, бат гэдэг нь худал үл өгүүлэхийг хэлж буй. Энэ нь бурхны номлолд хэлдэг таван санваарыг зааж, энэ

таван чанар нь ихэтгэж хэлбэл ертөнцийн тогтоолго, багатгаж хэлбэл хүний биеийн ахуй чанар, төрд авч хэлбэл бичиг цэрэг хоёулын сурлага, бурхан номд хэлбэл судар тарнийн сурлага ч болно гэх мэтээр бурхны шашны таван санваарын чухал чанарын тухай өгүүлсэн юм. Иймээс Мэргэн гэгээний галын судрын тус хэсэгт галыг бурхны шашны тэнгэр, бурхны шашны гурван эрдэнэ, бурхны шашны таван санваараас үүссэн хэмээн шүлэглэсэн билээ.

Хоёрдугаар мөрд нь галыг “Эртний богд ард тахисан” гэж, 3-10 дугаар бадгийн хоёрдугаар мөрд нь галыг “Хутаг их хаадын тахисан”, “Бишрэлт ард тахисан”, “Маш олон иргэд тахисан”, “Энэтхэг улс тахисан”, “Төвөд улс бас тахисан”, “Хятад улс бас тахисан”, “Үнэн Монгол улс тахисан” гэх мэтээр гал тахилгын дэлгэрсэн түүхэн улбааг шүлэглэжээ.

3-10 дугаар бадагт “хурц, билиг, магад, эрхэм, түмэн, хир, өндөр” төгс цогт галын хан гэх мэтээр солин, галын ханы эрдэм чадлыг тодруулан магтаж, “хувилгаант, бялдар сайт, мэдэл сайт, эрдэм сайт, хирт бус, өлзий хутаг, зургаан төгс арш тэнгэр” хэмээн тодотгож, галын хааныг арш тэнгэр дэх нэгэн цогц болгосны хамт түүний эрдэм, бялдар, мэдлийн төгс төгөлдөр шинжийн тухай шүлэглэжээ.

Хоёрдугаар хэсэг буюу 11-16 дугаар бадаг нь галын тэнгэрт тахил өргөл өргөх тухай шүлэглэжээ. Жишээлбэл:

“... Хүнд галын тэнгэр чамд

Хүж зул үр амсан⁴²

Хүргэ хувчдыг тахимуу

Хүрд насан цогийг соёрх ...” (Лувсандамбийжалцан, 1783: 2205) гэжээ.

Үүнд хүнд галын тэнгэрт хүж, зул, үр, амс, хувцас зэргээр тахиж соёрхол гуйсан байна. Дараачийн бадгуудад шидэм арз, шар тос, элдэв зүйлийн тахил, эрхэм зоог, их цагийн тахилаар тахимуй хэмээн шүлэглэдэг. Энэ “их тахил” гэдэг нь өвчүүг зааж байгаа болно.

Миний бие 2014 онд урадын 80 настай Гончиг ламыг сурвалжилсан юм. Гончиг гуайн ярихаар урад нутгийн монголчууд гал тахихдаа Мэргэн гэгээний галын судрын дагуу тахидаг бөгөөд “...Асаасан галдаа зассан өвчүү өргөх хүүхэн урьдаар галд гурав мөргөсний дараа өвчүүгээ савтай нь хадаг дээр тавьж үүд рүү харан, галын ерөөлийг чагнаж зогсоно. Галын ерөөл нь увай увай увай хамгаас сайн, увай увай их тахилыг, увай увай сайтар хувилгаан, увай галд мөргөмүй гэхтэй зэрэг өвчүү өргөдөг хүүхэн хурай хурай хурай их тахил, хурай хурай хурай сайтар хувилгаан, хурай хурай хурай галд өргөмүү гэж өвчүүгээ гурван удаа зөв эргүүлэн хурайлсны дараа галдаа зассан өвчүүгээ өргөнө ...” хэмээн хуучилж билээ. Үүнээс үзэхэд Мэргэн гэгээний галын ерөөл дэх их тахил нь даруй зассан өвчүүг зааж буй хэрэг. Урадууд галдаа зассан өвчүү өргөдөг.

Мөн тэрээр: “... Өвчүү засах гэдэг нь өвчүүний сүврэгийг гүйцэд үлдэнэ, ноос хий нь авна, өвчүүний гаднах дотнох ба цоройлохын махыг бүгдийг авна, гэвч хурууны ангал

⁴² Урад нутагт мах чанасан шөлөнд чавга, үзэм, айраг, ааруул, шар тос, цагаан будаа зэргийг хийж агшаасан будааг урад монголчууд амс гэж хэлдэг. Бас галын будаа гэдэг.

дахь махыг авч болохгүй, битүү үлдээнэ, хурууг нь арзайлгахгүй. Өвчүүний ноосыг зөв алгадаад эрчилж өвчүүг сүврэгтэй нь гурвалжлан ороогоод нэг савны хэлбэртэй болгоно. Дараа нь өвчүүний дунд нь олон эрдэнэ тавина. Тухайлбал таван өнгөтөн (таван өнгийн өөдөс), таван үнэртэн (арц, цай, агар, зандан, агь) таван амттан (таван зүйлийн идээ), таван цагаан (таван зүйлийн цагаан идээ), таван эрдэнэ (алт, мөнгө, оюу, шүүр, тана, сувд) таван хошуу малын ноос, нийт гучин зүйлийн юм. Дээр нь борви шаант нь холбоотой бүрэн, шаантаа таван өнгийн утсаараа орооно. Эсхүл таван хошуу малын ноосыг цувруулан сулхан ороодог. Үүний санаа нь нэг мал гал тахих үед галын бурханд бусад малыг дагуулж очоод даалгаж байх санаатай. Дээр нь сэмжин өөхөөр бүтээж, дээр нь амсаа тавьж, амсны дунд нь хонхорлож тос гол хийж зул асаана. Зассан өвчүүгээ галд өргөнө. Өвчүүг заавал нэг саванд нь засах хэрэгтэй. Өвчүүг галд өргөхөд саванд нь заавал өвчүүг засахад авсан мах, чавга зэрэг зүйл үлдсэн байх хэрэгтэй...” гэжээ. Их тахил гэдэг нь өвчүүгээ нэгэн сав шиг засаад дотор нь таван өнгөтэй, таван үнэртэн, таван амттан, таван цагаан, таван эрдэнэ, таван хошуу малын ноос гэх мэтээр үнэр, амт, өнгө, эрдэнээр баялаг тахил мөртөө таван хошуу малыг бүхнийг дагуулсан тул их тахил гэж байгаа нь тэр ажээ. Урад монголчууд одоо ч гал тахихад энэхүү уламжлалаа хадгалсаар байна.

Гуравдугаар хэсэг буюу 17-25 дугаар бадгуудад галын тэнгэрээс хишиг гуйх тухай шүлэглэжээ.

“... Шинж өлзий хутаг төгөлдөр

Шидийн санд арш тэнгэр

Шүтэн сахигч бидэн

Шадар ивээлийг өгтүгэй ...” (Лувсандамбийжалцан, 1783: 2206) гэгчээр төгөлдөр шинжит ид шидэт арш тэнгэр болох галын тэнгэрээс ивээл соёрхол өгтүгэй хэмээн шүлэглэхийн хамт энэхүү галын тэнгэр нь “Эртнээс улам тогтсон, өвгөдийн онгод тэнгэрээ” (Лувсандамбийжалцан, 1783: 2207) үүрд сахин атугай хэмээн даатгаж, дараа нь галын тэнгэрээс амь нас, адуу мал, ач үр, амар сайн, эрх хүч, эрдэм ном, эрхэм цог, энх мөнхийн хишиг соёрхлыг гуйсан байна.

Дөрөвдүгээр хэсэг буюу 26-27 дугаар бадаг нь даллага авах хэсэг юм.

“... Хутаг хэсэг лан бүгд

Хууяа хуу хутаг төгөлдөр

Хурай хурай хишиг ирүүл

Хурай хурай хутаг ирүүл

Хурай бүрэн ирүүл

Хурай хурай төгс ирүүл

Хурай хуран ирүүл

Хуран ирүүлж тогтуул ...” (Лувсандамбийжалцан, 1783: 2208) гэх мэтээр хишиг хутаг бүрэн төгс хуран ирүүлж тогтоохыг хурайлан далласан байна.

Тавдугаар хэсэг буюу 28-31 дүгээр бадаг нь өлзий өгүүлэх хэсэг болно.

“... Тэнгэр гэгээн тод өлзийтэй

Газар бат хутаг өлзийтэй

Хүн ёс журам өлзийтэй

Бүрэн өлзий хутаг ори

Очир лам ядам дагина

Очир номыг тэтгэн сахигч

Очир ори галын тэнгэр

Очир өлзий хутаг ори” (Лувсандамбийжалцан, 1783: 2208) хэмээн өлзий оршуулах шүлгээр төгсгөсөн байна.

Галын тахилга нь эгэл ардаас хутагт хаад хүртэл нийгмийн бүхий л давхаргын хүмүүсийн дунд энэтхэг, төвөд, хятад, монгол гэх мэт олон газар нутгаар маш өргөн дэлгэрсэн юм. Галын тэнгэрт өнгө үнэр амтаар бүрэн төгөлдөр тахилын дээжүүдийг өргөн, галын тэнгэрээс амь нас, адуу мал, эрүүл энх, эрдэм номын хишиг соёрхол гуйж, энэ бүхнийг бүрэн төгс хуран ирүүлж тогтоохыг хурайлан даллаж өлзий хутаг оршуулах шүлгээр төгсгөжээ.

Мэргэн гэгээнтэн эртний уламжлалт бөө мөргөлийн гал тахилгын ёс заншлыг бурхны шашны номлолын ёсонд нэн чадамгай уламжлуулсан билээ. Энэ тухай Германы монголч эрдэмтэн В.Хайссиг бээр “Мэргэн даяанч гэгээн Лувсандамбийжалцан маань ерөнхийлсөн хэлбэрээр бөө мөргөлийн шашны үзэлт болон онгод сахиусныг ламын шашны ёслол журамтай уялдуулж нэгтгэсэн залбирал даатгалын ном судрыг зохиож биелүүлсэн юм. Тэр бас өндөр газрыг шүтэх, гал тахих ба гэр мялаах зэрэг зан үйлд зориулж тун олон тахилга даатгалын ном судрыг зохион бичиж, ард иргэдийн дунд уламжлагдаж ирсэн хуучны шашин шүтлэгийн тахилга даатгалын ном судартбөө мөргөлийн шашны онгод сахиусныг хувируулаад ламын шашны ёслол зүйн бүхий л цогцод шингээж багтаасан байдаг. Тэрээр нэгэн зүйлийн шинэ журам ёслолыг зохион бүтээх гэж туршилт хийсэн бөгөөд зарим талаар маш их амжилтыг олсон юм” (Батцагаан, 2007: 6) гэжээ.

Гурав. Мэргэн гэгээний галын судрын туурвил зүйн онцлог.

Мэргэн гэгээний галын судрын бүтцийн онцлог. Мэргэн гэгээний галын судрыг бурхны шашны нөлөө багатай бөө мөргөлийн галын ерөөл болон Цахар гэвш Лусанцүлтэмийн галын тахилгын судартай харьцуулан шинжлэхэд Мэргэн гэгээний галын ерөөлийн бүтцийн онцлогийг олж харах юм. Мэргэн гэгээний галын судрыг Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнд хадгалагдаж байгаа хоёр гар бичмэлтэй харьцуулж үзье.

yal-un sang (Галын сан) нэрт бичмэл эх. Цаас. Чин улс (1616-1912)-ын дундаж үеийн хулсан үзгийн бичмэл. Хэмжээ нь 6.2×10.9 см. БНХАУ-ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд 49.72/64:10 дансны дугаартай хадгалагдаж байна. Нийт 23 хуудас.

yal-yi takiqu-yin jang üile bayasqulang-un yarqu-yin orun kemekü oruṣiba (Галыг тахихын зан үйл баясгалангийн гарахын орон хэмээх оршив) нэрт бичмэл эх. Цаас. Чин улс (1616-1912) -ын дундаж үеийн хулсан үзгийн бичмэл. Хэмжээ нь 7×17.7 см. БНХАУ-ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд 49.72/64:12 дансны дугаартай. Нийт 17 хуудас.

“Галын сан”-гийн бүтэц нь “дээр тэнгэрийн тэгш бүхий цагаас үүдсэн, доор этүгэн эхийн өлмий цагаас үүдсэн өрөв” галын үүссэн цаг, “хан эзний цохисон, хатан эхийн үлээсэн” галын үүсэл, “хатан төмөр эцэгт, хайр чулуун эхт, хайлсан модон улт” галын удам гарал, “дээр үүлэн нэвт илчит торгон нүүрт гал эх, тосон нүүрт тунгал эхт” галын дүр, “өөхөн тосон дусаан суунам” өргөл, “үүрд их жаргалангийн дунд ийн заяан атугай” соёрхол гуйх гэх мэтийн загварыг монголын ардын аман яруу найргийн зэрэгцүүллийн аргаар гурав давтсаны дараа даллагын үгс “тэнгэр нарын хан ерэн есөн тэнгэр нарын буян хишиг хурай, мөнх тэнгэр эцгийн чиний хишиг хурай хурай” зэргээр хишиг даллагын шүлгээр төгсдөг. Тус галын сангийн агуулгыг үзэхэд бурхны шашны агуулгатай үгс тун цөөн хийгээд зөвхөн даллага авах хэсэгт “Номын хан Шигэмүни бурхны буян хишиг, Очирын тэргүүтэн арван зүгийн бурхан бодисадын хишиг” гэх мэтийн агуулга нэмэгдэж орсон нь илэрхий. Тус галын сангийн бүтэц нь ерөнхийдөө гал үүссэн цаг, галыг үүсгэгч, галын удам, гал эхийн дүр байдал, гал эхэд өргөл өргөх, галаас хишиг соёрхол гуйх, галаас хишиг даллах гэсэн хэсгээс бүрдэж байна.

Мэргэн гэгээний галын судрын бүтцийг ажиглахад *“рашаант хумх барьсан, раднаа эрихийг татсан, ранзаа галын хаан”* галын дүр байдал, *“Эсрүүн тэнгэрээс болсон, эртний Богд ард тахисан, элдэв төгс цогт гал хан, Эрдэнэт ари тэнгэр”* галыг үүсгэгч, галын тахилга, галын шинж, *“Хүнд галын тэнгэр чамд, хүж зул үрс амсан, хүргэ хувчдаар тахимуу, хүрд насан цогийг соёрх”* галын тэнгэрт өргөл өргөх, *“амь насны хишиг соёрх, адуу малын хишиг соёрх, ач үрийн хишиг соёрх, амар сайны хишиг соёрх”* гэх мэтээр галын тэнгэрээс хишиг соёрхол гуйсан, *“хурай хурай бүрэн ирүүл, хурай хурай төгс ирүүл, хурай хурай хуран ирүүл, хуран ирүүлж тогтуул”* хишиг даллага авах, өлзий өгүүлэх гэх мэтийн бүтэцтэй. Энэ нь галын дүр байдал, галыг үүсгэгч, гал тахилгын дэлгэрэлт, галын шинж, галын тэнгэрт өргөл өргөх, галын тэнгэрээс хишиг соёрхол гуйсан, даллага авах, өлзий өгүүлэх гэсэн хэсгээс бүрдэхийг хэлж байна.

Цахар гэвш Лувсанчүлтэмийн “Галыг тахих зан үйл баясгалангийн гарахын орон хэмээх оршив” эхэд: *“хэрэгтнийг бэлдэх нь, нэгэн хонины өвчүү дотор шагайт чөмөг, дөрвөн өндөр хавирга, хялгана”, “гал тэнгэрийг үүсгэх инү, өмнөх огторгуйд ра-аас болсон галын цогцын дунд лянхуа сарны дээр гал тэнгэр маш цагаан өнгөт маш амарлингуй дүртэй”, “урин залах ану, айлдах энэрэхийн эрдэм хотол төгссөн, амарлингуй догшин элдэв хувилгааныг өчүүлэгч дорно өмнийн зовхисоос бэлгэ билигтэнд урин залаад тангараг танд шингээж ... шим ялгалгүй болбой”. “Энэ завсарт есөн зулыг шатааж өвчүүг тулган дотор тавь... Шим амт чадал бүхэн төгссөн ариун өвчүүг, шинэ цагаан утсаар үзэмжтэй ороосон ба шагайт чөмөг өндөр хавирга лугаа сэлтсийг, шүтээн гал тэнгэрийн чуулганд тахил болгон өргөмүй... Галбаранзын хувчид лугаа адил хүрвээс биед маш зөөлөн амгаланд хөнгөн нимгэн тэргүүтэн олон эрдэм төгссөн хүртээлийн дээд элдэв торго бүсийн зүйлээр тахимуу хэмээн бүс торгойн өөдсийг галд өргөх буюу эрхт гал тэнгэр нөхөр сэлт бүхэндээ эртээс энэ мэт тахил өргөдөг ёсчлон өдгөө бид бүгд ч хүндлэн тахисан үүн. Энэрэн нигүүлсэнгүйгээр баясаж зооглон соёрх,*

маш нигүүлсэхүй цаад хүрснээр маш хүссэн хур мэт буулгагч маш их хүчит гал тэнгэрийн чуулганд маш бишрэхүй сүсгээр сөгдөн мөргөмүй ...” гэх мэтээр өргөл мөргөл үйлдэх, “магтуу нь амь насыг урт болгон ивээхийн тулд аршийн дүрт дээд биеийг үзүүлээд, ад чөтгөр тэргүүтнийг амарлиулахын тулд асар цагаан өнгөөр хувилсныг магтмуй, үгүйрэхийн зовлонгоос аврахын тулд үлшгүй рашаант хумх бариад, үлэмж жаргаланд удирдахын тулд үзэсгэлэнт эрих барьсныг магтмуй” гэх мэтээр галын магтуу, “хүссэн хэргийг залбирах нь, эрх хүчин хотол төгссөн гал тэнгэрийн чуулган бээр, өргөсөн эдгээр тахилыг минь баясан зооглоод, эрж хүссэн ямар хэрэгтнийг хоцролгүй энэрэнгүй сэтгэлээр бүтээж хайрлан соёрх ...”, “хишиг даллахад даллагын идээг бариулаад, хэтэрхий асран нигүүлсэхүй төгссөн хэдий бүх авран ивээгчид бүгдээр хишиг буяныг даллан дуудах үүн дор, хэр мэт хүссэн хэргүүдийг ирүүлэн соёрх, хурай хурай...”, “Хүлцлийг өгүүлэх нь, аль бас бидний мэдэл чадал муугийн эрхээр ариун сайтар тахиж хүндлэн эс чадсан тэргүүтэн, алдал нүгэл хэдий чинээ бологсдыг гэмшин наманчилмуй”, “ерөөл нь эрхт богд лам нарын өлмий бататгаад, эрдэнэ шашин арван зүгт дэлгэрч, эх болсон хамаг амьтан насад жаргахын эрхийн сайнууд өнөд бадрах болтугай”, “ажааруулан хураах нь, эрх хүчин төгөлдөр гал тэнгэрийн чуулган бээр энэрч манай тусыг бүтээсэн маш ачтай болбой, өдгөө өөрийн орондоо ажран залраад үүрд сулдалгүй нигүүлсэхүйгээр айлдан соёрх”, “өлзий өгүүлэх нь хамаг ертөнцөд өвчин тахал хэрүүл тэмцэл тэргүүтэн хамаг үл зохилдохуун амарлиад ном ба эд мал хийгээд хамаг хүсэгдэхүүний учрал зуны уур мэт дэлгэрч, хамаг сайн буяны цогд цэнгэхийн өлзий хутаг орштугай” гэх мэтээр бэлтгэл, тэнгэрийг үүсгэх, урин залах, өргөл мөргөл үйлдэх, магтуу, хүссэн хэргийг залбирах, хишиг даллах, ерөөл, ажааруулан хураах, өлзий өгүүлэх гэсэн бүтэцтэй.

Энэ гурван галын судрын бүтцийг харьцуулж үзэхэд Галын санд гал үүссэн цаг, галыг үүсгэгч, галын удам, гал эхийн дүр байдал, гал эхэд өргөл өргөх, галаас хишиг соёрхол гуйх, галаас хишиг даллах гэсэн бүтэцтэй.

Мэргэн гэгээний Галын ерөөл нь галын дүр байдал, галыг үүсгэгч, галын тахилга, галын шинж, галын тэнгэрт өргөл өргөх, галын тэнгэрээс хишиг соёрхол гуйсан, хишиг даллага авах, өлзий өгүүлэх гэсэн бүтэцтэй байна.

Цахар гэвш Лувсанчүлтэмийн Галын судар нь бэлтгэл, гал тэнгэрийг үүсгэх, урин залах, өргөл мөргөл үйлдэх, магтуу, хүссэн хэргийг залбирах, хишиг даллах, ерөөл, ажааруулан хураах, өлзий өгүүлэх гэсэн бүтэцтэй.

Эдгээрийг харьцуулж үзэхэд галыг үүсгэх, галын дүр байдал, галд тахил өргөл үйлдэх, галаас хишиг соёрхол гуйх, хишиг даллага авах зэрэг агуулга нь ерөнхийдөө адилхан байна. Мэргэн гэгээний галын судар нь өмнөх үеийн галын судартай харьцуулбал бүтцийн хувьд арай дэлгэрэнгүй, харин сүүлийн үеийн гал тахих зан үйлийн судартай харьцуулбал нэлээд хураангуй бололтой. Энэ хоёр судраас нэлээд ялгаатай нь Мэргэн гэгээнтний гал тахилгын дэлгэрэлтийн тухай шүлэглэсэнд оршино.

Эрдэмтэн В.Хайссиг “Одоо бид Монголын буй бүхий аймгийн галын ерөөлийг мэдэх болжээ. Ерөөлүүд бол хэдэн зууны тэртээ оршиж байсан нэг загвараас үүсэлтэй” (Хайссиг, 2013: 144) гэж өгүүлсэн нь маш зүйтэй. Энэхүү хэв загварыг цагийн байдалд зохицуулан тасралтгүй баяжуулсан байна.

Мэргэн гэгээний галын судрын ардын аман яруу найргийн онцлог. Мэргэн гэгээний галын судар нь голцуу уламжлалт яруу найргийн хэлбэрийг хэрэглэжээ. Мэргэн гэгээний галын судар нь зэргэлдээ орших гишүүн өгүүлбэр буюу өгүүлбэрүүд нь өгүүлбэр зүйн адилавар хэлбэрээр давтсан зэрэгцүүллийг түгээмэл хэрэглэжээ. Түүний галын судрын бадгуудыг ажиглахад зарим нь нэг нийлмэл өгүүлбэр, зарим нь хоёр энгийн өгүүлбэрийн нийлбэр, зарим нь дөрвөн энгийн өгүүлбэрийн эн зэрэгцүүлээр бүтжээ. Энд ухаж ойлгоход дөхмийг бодолцож өгүүлбэрийн гишүүн хийгээд тэдгээрийн харьцааг доорх мэт тэмдгээр илтгэв. Үүнд: “+” тэмдгээр зэрэгцэх харьцаа, “>” тэмдгээр захирах харьцаа, “:” тэмдгээр авцалдах харьцаа, “S” үсгээр өгүүлэгдэхүүн, “P” үсгээр өгүүлэхүүн, “O” үсгээр тусагдахуун, “Ad” үсгээр байц, “At” үсгээр тодотголыг заав. Жишээлбэл:

“Эсрүүн тэнгэрээс болсон (At)

Эртний Богд ард тахисан (At)

Элдэв төгс цогт (At) гала хан (S)

Эрдэнэт ари тэнгэр (P)” гэх бадаг нь зэрэгцсэн тодотгол гишүүн өгүүлбэртэй нийлмэл өгүүлбэр. Даруй “At+ At+ At> S:P” загвартай өгүүлбэр. Тус загвартай өгүүлбэрийг 10 удаа зэрэгцүүлэн давтаж, галын бурхны үүсгэл ба гал тахилгын дэлгэрсэн түүхэн явцыг тодорхойлжээ.

“Хүнд галын тэнгэр чамд (O)

Хүж зул үрс амс

Хүргэ хувчдаар (O) тахимуу (P)

Хүрд насан цогийг (O) соёрх (P)” гэсэн бадаг нь өгүүлэгдэхүүнгүй хоёр энгийн өгүүлбэрийн нийлбэрээр бүрэлдсэн юм. Бүтцийг нь үзүүлбэл “O+O>P+O>P”. Тус загвартай өгүүлбэрийг 4 удаа давтаж, галын тэнгэрт өргөх өргөлүүдийг тусгажээ.

“Зуун оны асан чадахуй (O)

Зуун оны намар үзэхуй (O)

Зуун зүйлийн жаргал хүртэхуй(O)

Зуун хувь зол (O)ыг соёрх(P)”. Тэр нь “O+O+O+O>P” загвартай. Өмнөх гурав нь тусагдахуун гишүүн өгүүлбэр болох мөртөө эн зэрэгцүүллийн хэлбэрээр байрлуулж, галын бурхнаас урт насалж удаан жаргахын хишиг соёрхлыг гуйсан байна. Бас жишээлбэл эрх хүчин (At) хишиг (O) соёрх (P). “At>O>P” гэх загвартай өгүүлбэрийг найман удаа эн зэрэгцүүлэн давтаж, галын тэнгэрээс амь нас, адуу мал, ач үр, амар сайн, эрх хүч, эрдэм ном, эрхэм цог, энх мөнхийн хишиг соёрхлыг гуйжээ.

Академич Д.Цэрэнсодном “Монгол шүлгийн эн зэрэгцүүлэлтэйг ихэнхдээ адил утгат өгүүлбэр, эсрэг утгат өгүүлбэр, адилавар дуудлага өгүүлбэрийн хэлбэрээс илэрдэг гэж бас хэлж болох байна” (Цэрэнсодном, 1983: 161) хэмээн бичсэн юм. Мэргэн гэгээний галын судар нь адил утгат өгүүлбэр буюу гишүүн өгүүлбэрээр эн зэрэгцүүлсэн байна. Монгол шүлгийн эн зэрэгцүүлэх ёс нь маш эртний үүсвэртэй. Эртнээс монгол шүлгийн тогтолцооны гол хэмжээс болж байсан юм. Холбоц нь бас монгол уламжлалт шүлгийн

айзам зохицуулах гол арга юм. Мэргэн гэгээний галын сударт толгой холбохыг гол болгон хэрэглэж, зарим бадагт бас сүүл холбоцыг хэрэглэсэн байдаг. Мэргэн гэгээний галын судар нь нийт 30 бадагтай, дөрвөн мөрөөр бадаглаж, бадаг болгон холбоцын журмыг чанд баримталсан бөгөөд 28 бадаг нь толгойн жигд холбоцоор холбогджээ.

Мэргэн гэгээний галын судрын зохист аялууны онцлог. Мэргэн гэгээнтэн зохист аялгууны онолын дууны чимгийн үйлдэхүй хялбар хөлийн анхдугаарт байгаа хос төгөлдөр чимэг, үйлдэхүй бэрх бусад оронд байгаа хос төгөлдөр чимэг, холимог хос төгөлдөр чимэг зэрэг гурван зүйлийн хос төгөлдөр чимгийг хэрэглэсэн байдаг. Жишээлбэл:

“... Зуун оны асан чадахуй

Зуун оны намар үзэхүй

Зуун зүйлийн жаргал хүртэхүй

Зуун хувь золыг соёрх...” (Лувсандамбийжалцан, 1783: 2203)

Энд “зуун” гэх үгийг хөл (мөр) бүрийн эхэнд оруулан завсардсан хос төгөлдөр чимгийг үйлдэж галын сахиулснаас урт насалж удаан жаргах хувь золыг гуйж буй санааг товойлгожээ. Үүнээс гадна хөл (мөр) бүрийн дунд хос төгөлдөр чимэг завсардан орох ба хөл бүрийн эцэст завсардсан холимог хос төгөлдөр чимгийг хэрэглэсэн байна. Жишээ нь :

“... Эрх хүчний хишиг соёрх

Эрдэм номын хишиг соёрх

Эрхэм цогийн хишигийг соёрх

Энх мөнхийн хишигийг соёрх...” (Лувсандамбийжалцан, 1783: 2203)

Энд “хишиг” нь хөл бүрийн дунд нь, “соёрх” нь хөл бүрийн эцэст завсардан орж, хөлийн бусад оронд орсон үйлдэхүйеэ бэрх хос төгөлдөр чимгийг үйлдэж, галын сахиулснаас хишиг соёрхохыг онцлон тодруулжээ.

“... Хутаг хишиг лан бүгд

Хууяа хууяа хутаг төгөлдөр

Хурай хурай хишиг ирүүл

Хурай хурай хутаг ирүүл

Хурай хурай бүрэн ирүүл

Хурай хурай төгс ирүүл

Хурай хурай хуран ирүүл

Хуран ирүүлж тогтуул...” (Лувсандамбийжалцан, 1783: 2203)

Энэ хэсэгт дөрвөн хөл болгонд “хурай хурай”-г эс завсардуулсан ба хөл бүрийн эхэнд “хурай хурай”-г завсардуулан үйлдсэнээр үл барам хөл бүрийн эцэст “ирүүл”-г

завсардуулж гурван зүйлийн хос төгөлдөр холилдсон чимгийг бүтээж, хишиг хутаг бүрэн төгс хуран ирүүлж тогтоохыг хурайлан даатгасан байна.

“... Тэнгэр гэгээн тод өлзийтэй

Газар бат хутаг өлзийтэй

Хүн ёс журам өлзийтэй

Бүрэн өлзий хутаг орш.

Очир лам ядам дагина

Очир номыг тэтгэн сахигч

Очир арш галын тэнгэр

Очир өлзий хутаг ори ...” (Лувсандамбийжалцан, 1783: 2203)

Үүнд “өлзийтэй” гэх үгээр нэг, хоёр, гуравдугаар хөлийн эцэст завсардсан хос төгөлдөр чимгийг зохиож, тэнгэр газар хүн гурвын өлзийг зөгнөж, “очир” гэх үгээр хөл болгоны эхэнд завсардсан хос төгөлдөр чимгийг бүтээж, лам ядам дагина, номыг тэтгэн сахигч, арш галын тэнгэр нарын очир өлзий хутаг орших ерөөлийг тавьжээ.

4. Дүгнэлт

Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны галын судар нь агуулгын хувьд уламжлалт галын судар дахь торгон нүүрт буюу тосон нүүрт гал эх буюу ханыг хувируулаад рашаант хумхаа барьсан, раднаа эрх татсан галын хан арш тэнгэр болгож, төмөр эцэгт чулуун эхтээс үүсдэгийг хувируулаад Эсрүн, Хурмаст тэнгэрээс үүсэх болгожээ. Зохиолын бүтцийн хувьд уламжлалт галын судрын загварт суурилан, эхэнд нь тахилын шүлэг, төгсгөлд нь өлзий оршуулах шүлэг нэмсэн, уран сайхны арга хэрэглүүрийн хувьд ардын аман яруу найргийн зэрэгцүүлэл, холбоцыг элбэг ашигласнаар үл барам Энэтхэг төвөдийн шүлгийн нөлөөгөөр зохист аялгууны дууны чимгийн аргыг ч хэрэглэжээ. Иймээс Мэргэн гэгээнтэн бөөгийн шашин ба бурхан шашны хоорондох харьцаанд авч үзэхийн зэрэгцээ бөөгийн шашны үзэлт ба эзэд сахиулсныг бурхан шашны ёс горимтой уялдуулахыг чармайж, монголын ардын аман зохиол ба бичгийн зохиол, монголын уламжлалт соёл ба харь соёлын харилцан хамаарлын асуудлыг шийдвэрлэсэн, гал тахилгын түүхийн тухай өгүүлсэн нь түүний галын судрын бас нэгэн товойсон онцлог болжээ.

1783 оны модон барын эхийг Бээжинд гэрэл зургаар хэвлэсэн эхээс зургийг хавсаргав.

Зураг №1. Галын ерөөлийн судар хэмээгдэх оршив судрын гарчиг,
эхний нүүр хуудас



Ном зүй:

Сурвалж, эх бичиг:

- *yal-un irügel orusiba*. Цаас. хулсан үзгийн гар бичмэл. 7.6×18.9. БНХАУ-ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан. 49.72/343/:1. Хуудас 10.
- *yal tngri-yin takily-a*. Цаас.хулсан үзгийн гар бичмэл. 7.3×22.2. БНХАУ-ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан. 49.72/189/:1. Хуудас 10.
- *yal-un takily-a orusiba*. Цаас. хулсан үзгийн гар бичмэл. 5.9×14.4. БНХАУ-ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан.49.72/342/:1. Хуудас 12.
- *yal-un takilay-a orusiba*. Цаас. хулсан үзгийн бичмэл. 7×30.5. БНХАУ-ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан. 49.72/206:3. Хуудас 8.
- *ejen boyda-yin sang*. Цаас. үсэн үзгийн бичмэл. 21.8×10.8. БНХАУ-ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан. 49.720/9/:3. Хуудас 31.
- *yal-un sang*. Цаас. хулсан үзгийн бичмэл. 6.2×10.9. БНХАУ-ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан. 49.72/64:10. Хуудас 23.
- *yal-yi takiqu-yin jang üile bayasqulang-un yarqu-yin orun ketekü orušiba*. Цаас.хулсан үзгийн бичмэл.7×17.7. БНХАУ-ын Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан.49.72/64:12. Хуудас 17.

Лувсандамбийжалцан. Очирдара Мэргэн даяанч ламын гэгээний бум зарлиг хэмээгдэх оршвой. IV боть. Бээжин., 1783 (гэрэл зургаар)

Лувсандамбийжалцан. Алтан товч. 1763

Монгол хэлээр:

Батцагаан, Мөнх.Ба, Лхам, (2007). *Мэргэн гэгээн судлалын чуулган*. Хайлаар. [Battsagaan, Mönkh.Ba, Lkham, Mergen gegeen sudlalyn chuulgan, [Khailaar. Mergen Gegen Studies Conference, 2007]

Галлуу, С. Жарантай, Г. (1986). *Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны бум зарлиг хэмээгдэх оршив.* Үндэстний хэвлэлийн хороо. [Mergen gegeen Luvsandambijaltsany bum zarlig khemeegdekh orshiv. [The Hundred Thousand Decrees of the Wise Saint Luvsandambijaltsan. Compiled by Galluu & Jarantai (Eds.), Series of Mongolian Classical Scripts. Huhhot: Nationalilty Publishing Committee, 1986]

Дамдинсүрэн, Ц. (1959). *Монгол уран зохиолын дээж зуун билэг оршивой.* Улаанбаатар, [Ts.Damidinsüren, Mongol uran zokhiolyn deej zuun bileg orshvoi, One Hundred Literary Treasures of Mongolian Literature. Ulaanbaatar, 1959]

Мөнх, Ба. (2004). *Урадын Мэргэн гэгээний утга соёлын үйл ажиллагааны уламжлал шинэчлэл.* Хайлаар. [Ba. Mönkh, Uradyн mergen gegeenii utga soyolyn үйл ажillagaany ulamjлal shinechlel, radition and Renewal in the Literary and Cultural Activities of Urad Mergen Gegen, Khailaar, 2004]

Мөнх, Ба (2019). *Урад судлалын сонгомол өгүүллүүд.* Хайлаар [Ba. Mönkh, Urad судlалын songomol өгүүллүүд, Selected Papers in Urad Studies, Khailaar, 2019]

Хайссиг, В. (2013). *Монголын шашин суртахуун.* Хөххот. [W. Hessig, Mongolyn shashin surtakhуun, [Religious and Moral Traditions of Mongolia, Khökhkhot, 2013]

Хишигтогтох, Ц. (2013). *Ц.Хишигтогтохын өгүүллийн сонгодог* (доод боть). Хөххот. [Ts.Khishigtogtokh, Ts. Khishigtogtokhyn өгүүллийн songodog (dood boti), Selected Classical Essays of Ts. Khishigtogtokh, Khökhkhot, 2013]

Цэрэнсодном, Д. (1983). *Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал.* Хөххот.,1983. [D.Tserensodnom, Mongol shүлгийн onol түүхийн зарим асуудал, [Mongol shүлгийн onol түүхийн зарим асуудал [Some Issues in the Theory and History of Mongolian Poetry], Ulaanbaata, 1983]

Цэцэнцогт. (1988). *Монгол үгсийн язгуурын толь.* Хөххот. [Ttsentsogt, Mongol үгсийн язгуурын toli, Etymological Dictionary of Mongolian Words, Khökhkhot, 1988]

Хятад хэлээр:

- [西德]卡尔·J·赖歇尔著, 朝戈金译. (1990年2期月). 南斯拉夫和突厥英雄史诗中的平行式: 程式化句法的诗学探索. 民族文学研究.

- 鲜益. (2004). 彝族口传史诗的语言学诗学研究. 四川: 四川大学博士论文.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>